

тохирсон орон сууц олоход туслуулах юм бол тэдний үйлчилгээ бүр нь төлбөртэй гэдгийг анхаарах хэрэгтэй. БНЧУ-д иргэн бүр орон сууц, байр хайж болно, эсвэл үл хөдлөх хөрөнгийн агентлагийн үйлчилгээг ашиглаж болно. Хэрвээ та үл хөдлөх хөрөнгийн агентлагтай холбогдож өөрт.

Орон сууц, байшинг ашиглахтай холбоотойгоор хураамжуудыг төлдөг.

#### Хураамжийг сар бүр тогтмол төлнө.

- түрээс
- концессын хураамж (зурагт болон радио хураамжууд) – дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэж байна
- эрчим хүчний урьдчилгаа төлбөр (цахилгаан, хий)
- орон сууц, байшин ашиглахтай холбоотой үйлчилгээний урьдчилгаа төлбөр (ус, бохирын хоолой цэвэрлэх, нийтийн эзэмшлийн талбайн гэрэлтүүлэг, хотын хог хаягдлын хаях – зарим хотод төлбөргүй байдаг, эсвэл цахилгаан шат болон бусад урьдчилгаа төлбөрүүд).

Эдгээр урьдчилсан төлбөрүүдийн дүн нь жилийн тайлан тооцоонд бодогдоно. Тайлан нь нэмж мөнгө төлөх эсвэл үлдэгдэл мөнгө авч болно.

- NEDOPLATEK (нэмж мөнгө төлөх) – энэ тохиолдолд та заасан хугацаанд нэмж төлбөр төлөх ёстой. Хэрвээ та төлбөрөө нэмж төлөөд, эсвэл нэмж төлөхийг хүсэхгүй бол сар бүр төлдөг урьдчилгаа төлбөрийн хэмжээг нэмэхийг санал болгож байна

- PŘEPLATEK (үлдэгдэл мөнгө авах) – энэ тохиолдолд танд урьдчилгаа төлбөрөөс үлдэгдэл ирнэ, эсвэл үлдэгдэл мөнгө дараагийн улиралд орж болно.

Жилийн тайлангийн мэдэгдлийг шуудан эсвэл цахим шуудангаар илгээдэг.

### !!! POZOR !!!

- **ОРШИН СУУГАА ХАЯГАА БҮХ ГАЗАР ЗӨВ МЭДЭГДСЭН БАЙХ ХЭРЭГТЭЙ.** Зөвхөн нэг байнгын оршин суух хаягтай байна. Жинхэнэ оршин суугаа газартай байнгын оршин суух хаяг ижил байх албагүй. Энэ тохиолдолд захидал хүлээн авах хаягийг (эсвэл хүргэх хаягаа) бүх захиргааны газрууд болон байгууллагад мэдээлэх нь чухал юм.
- Хүргэх хаягийн тухай илүү ихийг [эндээс](#).

*Бид оршин суух сэдвээр дараах зүйлсийг бэлтгэж байна: концессын хураамж (зурагт болон радио), ачаа – захидал хүргэх.*